




МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2017 2-Р САР

Цахим сонин

Дугаар 50






Зах зээлийн тойм


/2017.02.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	18
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	35,789,024,459
Хувьцаа	944,841,457
Засгийн газрын үнэт цаас /анхдагч/	29,484,252,782
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	5,359,930,220
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	1,634,222
Хувьцаа	1,264,967
Засгийн газрын үнэт цаас /анхдагч/	314,886
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	54,369
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	2,194


Зах зээлийн үнэлгээ



MSE ALL индекс



TOP-20 индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	226
Төрийн өмчийн /100%/	19
Төрийн өмчийн оролцоотой	15
Хувийн өмчийн	192
I ангилал	7
II ангилал	46
III ангилал	174

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	58
Тусгай зөвшөөрөл /Андаррайтер, Брокер, Дилер/	26
Тусгай зөвшөөрөл /Брокер, Дилер/	29



Үнэт цаасны компанийн арилжааны идэвх

/2017.02.28-ны байдлаар/

Сим бол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/
		Тоо ширхэг	Үнийн дүн	Тоо ширхэг	Үнийн дүн	
1	Новел инвестмент ХХК	91,024	8,015,172,814	51,372	3,509,138,982	11,524,311,796
2	БиДиСек ХК	432,722	9,555,712,439	324,456	243,675,785	9,799,388,223
3	Голомт секюритиз ХХК	188,938	6,577,453,741	70,449	49,548,925	6,627,002,666
4	Дэү Секьюритис Монгол	36,465	3,173,404,113	19,095	1,863,973,700	5,037,377,813
5	Тэнгэр капитал ХХК	51,022	4,607,302,851	0	0	4,607,302,851
6	Ард капитал групп ХХК	101,855	1,101,308,246	159,406	27,999,366	1,129,307,612
7	Нэйшнл сэкюритис ХХК	10,197	932,046,588	3,484	1,508,941	933,555,529
8	Стандарт инвестмент ХХК	66,407	580,410,932	75,080	33,971,566	614,382,498
9	Дэлгэрхангай секюритиз ХХК	51,859	176,859,007	92,876	241,105,030	417,964,037
10	Ти Ди Би Капитал ХХК	122,794	266,860,501	69,137	54,599,189	321,459,690
11	Гаули ХХК	137,047	130,549,494	217,006	87,468,297	218,017,791
12	Азиа Пасифик секьюритис ХХК	17,761	154,911,735	17,658	14,762,085	169,673,820
13	Эм Ай Би Жи ХХК	162,026	115,058,407	10,720	2,733,822	117,792,229
14	Монсек ХХК	12,739	91,872,446	21,896	24,679,308	116,551,754
15	Бумбат-Алтай ХХК	31,071	77,183,464	75,408	30,362,242	107,545,706
16	Ард секюритиз ХХК	46,352	84,983,619	2,215	10,185,156	95,168,775
17	Зэргэд ХХК	15,322	63,483,720	18,635	25,455,473	88,939,193
18	Блүмсбюри секюритиес ХХК	13,423	59,872,225	10,593	6,346,164	66,218,389
19	Таван богд ХХК	0	0	28,945	27,452,330	27,452,330
20	Санар ХХК	2,614	356,884	31,819	16,058,886	16,415,770

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2017.02.28-ны байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт /хувь/	Зах зээлийн үнэлгээ /тэрбум/
1	TTL	ТАВАН ТОЛГОЙ	122,499	472,505,189	5,160	3,200	4,992.00	51.36	262.90
2	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	188,188	71,111,452	414	360	401.88	11.57	40.02
3	GOV	ГОВЬ	5,248	58,319,260	12,770	10,500	12,580.00	19.47	98.14
4	EER	АРИГ ГАЛ	24,585	56,526,931	2,300	2,190	2,300.00	0.00	8.00
5	APU	АПУ	152,205	50,763,422	355	285	337.77	-3.97	250.92
6	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,298	43,541,810	19,500	18,700	19,490.00	2.52	19.95
7	BNG	БАЯНГОЛ ЗБ	555	21,979,700	41,000	35,000	40,000.00	-2.82	16.92
8	MMX	МАХИМПЕКС	7,480	19,441,718	2,700	2,511	2,600.00	0.58	9.88
9	SUU	СҮҮ	132,207	16,979,138	135	124	128.26	3.43	44.12
10	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	274,532	14,580,354	60	48	54.00	-10.00	5.40
11	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	25,252	13,764,476	610	516	540.00	-9.43	19.88
12	NEH	ДАРХАН НЭХИЙ	558	10,775,730	20,480	19,120	20,000.00	4.71	22.11
13	BAN	БАГАНУУР	5,573	10,754,710	1,990	1,800	1,950.00	2.52	40.90
14	GTL	ГУТАЛ	884	10,108,800	12,730	11,310	11,330.00	-10.93	18.34
15	TMZ	ТӨМРИЙН ЗАВОД	1,319	9,271,230	8,900	7,005	7,900.00	-19.80	0.59
16	HBO	ХАЙ БИ ОЙЛ	54,122	7,684,270	152	140	140.98	-5.70	7.35
17	SHG	ШАРЫН ГОЛ	2,937	6,492,660	2,400	2,100	2,300.00	-4.17	23.39
18	RMC	РЕМИКОН	127,550	6,384,270	53	46	47.31	-13.98	3.72
19	MBG	МОНИТ БУЛИГААР	628	5,652,000	9,000	9,000	9,000.00	0.00	3.60
20	ADL	АДУУНЧУЛУУН	3,009	5,575,831	2,100	1,750	2,000.00	13.96	6.30



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2017.02.28-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /төгрөг/	Өөрчлөлт
			2016-12-31	2017-01-31		
1	АЛТАНДУУЛГА	174	874.17	1,330.00	455.83	52.14
2	ТАВАН ТОЛГОЙ	122,499	3,298.00	4,992.00	1,694.00	51.36
3	ДАВААНБУЛАГ	202	150.00	198.37	48.37	32.25
4	ЧАЦАРГАНА	6	425.02	560.00	134.98	31.76
5	МЕРЕКС	13,452	60.00	76.59	16.59	27.65
6	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	345	1,700.00	2,160.00	460.00	27.06
7	ГОВЬ	5,248	10,530.00	12,580.00	2,050.00	19.47
8	ХӨХ ГАН	46,997	53.56	62.00	8.44	15.76
9	МОНГОЛ НЭХМЭЛ	252	3,973.00	4,572.00	599.00	15.08
10	ДАРХАН ХҮНС	5	4,252.00	4,889.00	637.00	14.98
11	АДУУНЧУЛУУН	3,009	1,755.00	2,000.00	245.00	13.96
12	ХОРИНХОЁРДУГААР БААЗ	500	220.00	250.00	30.00	13.64
13	БЭРХ УУЛ	44	710.00	800.00	90.00	12.68
14	ХАСУ МАНДАЛ	31	4,000.00	4,500.00	500.00	12.50
15	БАЯН АЛДАР	1	1,069.00	1,200.00	131.00	12.25
16	МОНГОЛ ШУУДАН ХК	188,188	360.21	401.88	41.67	11.57
17	МОНГОЛ АЛТ	1	4,500.00	5,000.00	500.00	11.11
18	УЛААНБААТАР ХИВС	57	9,000.00	9,915.00	915.00	10.17
19	МАТЕРИАЛИМПЕКС	659	8,250.00	8,945.00	695.00	8.42

Ханшийн бууралттай хувьцаа

/2017.02.28-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт Төгрөг/	Өөрчлөлт
			2016-12-31	2017-01-31		
1	ЕВРОФЁ АЗИА	1,405	1,200.00	750.00	-450.00	-37.50
2	МОНГОЛ САВХИ	389	779.08	608.06	-171.02	-21.95
3	ТӨМРИЙН ЗАВОД	1,319	9,850.00	7,900.00	-1,950.00	-19.80
4	УБ БҮК	353	460.00	379.00	-81.00	-17.61
5	АВТОИМПЕКС	586	2,049.00	1,702.00	-347.00	-16.94
6	ХЭРЛЭН ХИВС	958	100.00	85.02	-14.98	-14.98
7	ИХ БАРИЛГА	113	3,850.00	3,300.00	-550.00	-14.29
8	ГАН ХИЙЦ	8	12,800.00	11,000.00	-1,800.00	-14.06
9	РЕМИКОН	127,550	55.00	47.31	-7.69	-13.98
10	ГУТАЛ	884	12,720.00	11,330.00	-1,390.00	-10.93
11	ЖЕНКО ТУР БҮРО	274,532	60.00	54.00	-6.00	-10.00
12	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	25,252	596.25	540.00	-56.25	-9.43
13	СОР	27	1,677.00	1,550.00	-127.00	-7.57
14	БИДИСЕК	385	1,490.00	1,390.00	-100.00	-6.71
15	ДАРХАН ЗБ	5	15,000.00	14,000.00	-1,000.00	-6.67



“Гермес Центр” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Гермес центр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 01 сарын 31 өдрийн №02 тоот тогтоолоор 2016 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашиг болох 323.6 сая төгрөгийн 98.9 хувь болох 320 сая төгрөгийг хувыцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр тарааж үлдсэн 3.6 сая төгрөгийг компанийн цалин урамшуулал болон нөөцийн санд тус тус хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Гишүүнчлэлийн жилийн хураамжийг хөнгөллөө



Монголын Хөрөнгийн Бирж анхны арилжаагаа зохион байгуулсан өдөр буюу “Дилерүүдийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлээ



Монгол Улсын Компанийн хуулийн 83.1 зүйл, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 8.10.11 заалт, гишүүнчлэлийн журмын 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн гаргасан Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын А/19 тоот тушаалын дагуу 2016 онд хийгдсэн арилжааны үнийн дүнгээр тэргүүлэн, МХБ-ийн нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний гүйлгээг хийсэн нэр бүхий 5 гишүүн үнэт цаасны компанийг 2017 оны гишүүнчлэлийн жилийн хураамжаас тус бүр 10 хувийн хөнгөлөлт эдлүүлэхээр боллоо.

Монгол улсад хөрөнгийн зах зээлийн анхны арилжаа зохион байгуулагдсан өдөр буюу **Дилерүүдийн өдрийг** тохиолдуулан Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны удирдлагууд болон брокер, дилерүүдийн төлөөлөл МХБ-ийн 5408 дахь арилжааг нээж цан цохиллоо.

Энэхүү өдрийг тохиолдуулан зарим гишүүн үнэт цаасны компаниудын удирдлага болон брокер, дилерүүдийг “Хөрөнгийн зах зээлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагналаа.





Хувьцаат компаниудад хугацаатай даалгавар өглөө

Санхүүгийн зохицуулах хорооноос хувьцаат компаниудад Аудитын тухай, Компаний тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд, эдгээртэй холбоотой тогтоол шийдвэр, зохицуулалтын журам, заавар болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагыг хангаж ажиллах талаар хугацаатай үүрэг даалгавар өглөө.

Даалгавраар, хувьцаат компаниуд Хороонд бүртгэлтэй хөрөнгийн үнэлгээний компаниар энэ оны хоёрдугаар улиралд багтаан хөрөнгийн үнэлгээ хийлгэж, өөрчлөлтүүдийг санхүүгийн тайланд тусган, дүгнэлтийг эхний хагас жилийн тайлантай хамт ирүүлэх, санхүүгийн тайландаа Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар заавал аудит хийлгэж байх, ногдол ашгийг тухайн жилд багтаан “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчийн дансанд шууд байршуулж байх, өмнөх жилүүдэд ногдол ашгийг компани дээрээ олгодог байсан бол хуваарилсан ногдол ашгийн тооцоог бүрэн гаргаж ирүүлэхийг үүрэг болголоо.

Түүнчлэн “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг мөрдөж ажиллах, “Компанийн засаглалын кодекс”-ийг хэрхэн хэрэгжүүлж байгаа тайлбар, холбогдох материалыг энэ оны гуравдугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг мэдэгдсэн байна. Мөн хувьцаат компани заавал өөрийн цахим хуудастай байх, идэвхтэй ажиллуулахыг санууллаа.

Өгсөн даалгаврыг дурдсан хугацаанд биелүүлээгүй, тайлан, тайлбар болон холбогдох материалыг Хороонд ирүүлээгүй тохиолдолд хуулийн дагуу хариуцлага ногдуулахыг анхааруулсан байна.

Даалгаврыг эндээс бүрэн эхээр нь үзнэ үү.

“Дэү Секьюритис Монгол ҮЦК” оноосон нэрээ “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК болгон өөрчиллөө

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017 оны 1 дүгээр сарын 27-ний өдрийн 63 дугаар тушаалаар Монголын хөрөнгийн биржийн гишүүн “Дэү Секьюритис Монгол ҮЦК” ХХК-ийн оноосон нэрийг “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК” ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсөн байна.

“Тахько” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Тахько” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 02-р сарын 09-ны өдрийн №1 тоот тогтоолоор 2016 оны цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 108 төгрөг буюу нийт 128.5 сая төгрөгийн ногдол ашиг тараахаар болов.

Энэхүү ногдол ашгийг 2017 оны 05-р сарын 01-ний дотор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК-тай гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар олгохоор болов.

“Говь” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Говь” ХК 2016 оны санхүүгийн үр дүнг харгалзан ТУЗ-ийн 2017 оны 02-р сарын 10-ны өдрийн №02 тоот тогтоолоор нэгж хувьцаандаа 200 төгрөг буюу нийт 1.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар болов.

Энэхүү ногдол ашгийг 2017 оны 4-р сарын 20-ны өдрөөс эхлэн компани дээрээ бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх байдлаар тараах ба ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоохоор болсон байна



“АПУ” ХК 2016 оны жилийн эцсийн тайлангаа ирүүллээ

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “АПУ” ХК 2016 оны жилийн эцсийн тайлангаа ирүүллээ.

Тус компани 2016 онд 208 тэрбум төгрөгийн орлого олж 2.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг Энд дарж үзнэ үү.

“Талх Чихэр” ХК 2016 оны жилийн эцсийн тайлангаа ирүүллээ

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Талх чихэр” ХК 2016 оны жилийн эцсийн тайлангаа ирүүллээ.

Тус компани 2016 онд 32.5 тэрбум төгрөгийн орлого олж 1.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг Энд дарж үзнэ үү.

“Монгол Шуудан” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 02-р сарын 14-ны өдрийн №17/05 тоот тогтоолоор нэгж хувьцаандаа 3,03 төгрөг буюу 2016 оны нийт цэвэр ашгийн 30 хувь болох 301.9 сая төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ тараахаар болов.

Энэхүү ногдол ашгийг 2017 оны 5-р сарын 1-ны өдрөөс эхлэн тарааж эхлэх ба ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоохоор болсон байна.

“Таван толгой” ХК 2016 оны жилийн эцсийн тайлангаа ирүүллээ

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Таван толгой” ХК 2016 оны жилийн эцсийн тайлангаа ирүүллээ.

Тус компани 2016 онд 176.5 тэрбум төгрөгийн орлого олж 54.04 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг Энд дарж үзнэ үү.

“Дархан Нэхий” ХК 2016 оны жилийн эцсийн тайлангаа ирүүллээ

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Дархан нэхий” ХК 2016 оны жилийн эцсийн тайлангаа ирүүллээ.

Тус компани 2016 онд 13.8 тэрбум төгрөгийн орлого олж 1.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг Энд дарж үзнэ үү.

“Мах Импекс” ХК 2016 оны жилийн эцсийн тайлангаа ирүүллээ

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Мах импекс” ХК 2016 оны жилийн эцсийн тайлангаа ирүүллээ.

Тус компани 2016 онд 7.5 тэрбум төгрөгийн орлого олж 1.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг Энд дарж үзнэ үү.



Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын анхааралд

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.6, болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.3 зүйлд заасны дагуу жилийн эцсийн тайлангаа 02-р сарын 10-ны дотор Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх үүрэгтэй байдаг.

2017 оны 02-р сарын 20-ны байдлаар нийт бүртгэлтэй 226 хувьцаат компаниас нэр бүхий 127 компани нь МХБ-д санхүүгийн тайлангаа ирүүлээд байна.

Харин дараах жагсаалтанд нэр дурьдагсан хувьцаат компаниуд нь санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байгаа бөгөөд заасан хугацаанд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд СЗХ-ны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам” болон МХБ-ийн холбогдох журмууд ба Бүртгэлийн гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг ногдуулах болохыг анхаарна уу.

Иймд бүртгэлтэй компаниуд хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангаж 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа яаралтай ирүүлэхийг дахин мэдэгдэж байна.

“Мах Импекс” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Мах импекс” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 02-р сарын 15-ны өдрийн №03 тоот тогтоолоор нэгж хувьцаандаа 100 төгрөг буюу нийт 380 сая төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ тараахаар болов.

Энэхүү ногдол ашгийг 2017 оны 10-р сарын 1-ны өдрөөс эхлэн өөрийн компанийн байранд тараах ба ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоохоор болсон байна.

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн 2016 оны үндсэн үйл ажиллагааны үр ашиг

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 2016 онд нийт 49.0 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа, 299.6 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасны арилжааг тус тус зохион байгуулж, хувьцааны арилжааны дүнг өмнөх оноос 60.6%-аар буюу 18.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан байна.

Хувьцааны тухайд арилжааны дүн сүүлийн 3 жил дараалан тасралтгүй өссөн бөгөөд Засгийн газрын үнэт цаасны тухайд анхдагч зах зээлийн арилжаа 2016 оны 5 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд биржээр огт явагдаагүйтэй холбоотой ЗГҮЦ-ны арилжааны дүн анхдагч зах зээл дээр өмнөх оноос буурсан хэдий ч хоёрдогч зах зээл дээр өмнөх оноос 3.7 дахин өссөн үзүүлэлттэй байгаа юм.

Биржийн арилжааны сүүлийн 3 жилийн динамик (тэрбум төгрөгөөр)

№	Арилжааны төрөл	2014 он	2015 он	2016 он
1	Хувьцааны арилжаа	24.2	30.5	49.0
2	Засгийн газрын үнэт цаасны арилжаа	36.1	515.4	299.6
	Үүнээс: Анхдагч зах зээл	36.1	510.3	280.4
	Хоёрдогч зах зээл	-	5.1	19.2

Дэлгэрэнгүйг [энд](#) дарж үзнэ үү.

Компани нь 2016 онд үндсэн үйл ажиллагаанаас нийт 1,176 сая төгрөгийн орлого олж, 2,545 сая төгрөгийн зардал гарган, 1.3 тэрбум төгрөгийн цэвэр алдагдалтай ажилласан нь 2015 оны үндсэн үйл ажиллагааны цэвэр алдагдлын дүнг 713.9 сая төгрөгөөр буюу 34.3%-аар бууруулж чадсан байна.

2016 оны үндсэн үйл ажиллагааны орлогын 59%-ийг арилжааны шимтгэлийн орлого, 23%-ийг бүртгэлтэй ХК болон гишүүн ҮЦК-уудын жилийн хураамжийн орлого, 18%-ийг бусад үйл ажиллагааны орлого тус тус эзэлж байна.

Компанийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг олон улсын туршлагатай “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитын дүгнэлт,



зөвлөмжийг үндэслэн “Ажлын мастер гэрээ”-ний хүрээнд Монгол Улсын төсвөөс 2011-2015 онд тус компанид олгосон нийт 20 тэрбум төгрөгийн санхүүжилтийг компанийн санхүүгийн тайланд “эздийн өмч” хэсэгт бүртгэхийг хүлээн зөвшөөрч, хувьцаа эзэмшигчийн зүгээс санхүүжилтийн дүнгээр дүрмийн санг нэмэгдүүлэх шийдвэрийг 2016 онд гаргасан ба холбогдох бүртгэлийг санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан болно.

Ийнхүү компанийн 2016 оны үндсэн үйл ажиллагааны зардлын 43% буюу 1.1 тэрбум төгрөгийг дээрх гэрээний хүрээн дэх хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц болох МИТ системийн ашиглалтын болон лицензийн элэгдэл, хорогдлын жилийн зардал, 38%-ийг ажилтнуудын цалин, НДШ-ийн зардал, 19%-ийг үйл ажиллагааны бусад зардал тус тус эзэлж байна.

“Баянгол Зочид Буудал” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Баянгол зочид буудал” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 2-р сарын 17-ны өдрийн №02 тоот тогтоолоор нэгж хувьцаандаа 355 төгрөг буюу нийт 150.1 сая төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ тараахаар болов.

Энэхүү ногдол ашгийг 2017 оны 9 сарын 1 өдрөөс эхлэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК болон өөрийн компанийн байранд тараах ба ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2017 оны 3 сарын 31 өдрөөр тасалбар болгохоор болсон байна.

“АПУ” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“АПУ” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 02-р сарын 17-ны өдрийн №17/08 тоот тогтоолоор 2016 оны бизнесийн үйл ажиллагааны үр дүнг харгалзан үзэж нэгж хувьцаандаа 1 төгрөг буюу нийт 741.6 сая төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ тараахаар болов.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоохоор болсон байна.

“Улаанбаатар Хивс” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 2-р сарын 22-ны өдрийн №06/2017 тоот тогтоолоор нэгж хувьцаандаа 75 төгрөг буюу нийт 30.3 сая төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ тараахаар болов.

Энэхүү ногдол ашгийг 2017 оны 5 сарын 1-15 өдрийн хооронд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах ба ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2017 оны 3 сарын 10 өдрөөр тогтоосон байна.

“Ган Хийц” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Ган хийц” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 2-р сарын 17-ны өдрийн №003 тоот тогтоолоор нэгж хувьцаандаа 100 төгрөг буюу нийт 24.2 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар болов.

Энэхүү ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах ба ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2017 оны 3 сарын 4 өдрөөр тогтоосон байна.

“Атар Өргөө” ХК-ийн үнэт цаасны арилжааг түр зогсоолоо

“Атар өргөө” ХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийсэн “Фискал аудит” ХХК-ийн зөвлөмж, тус компанийн хүсэлтийг үндэслэн гаргасан СЗХ-ны улсын байцаагчийн 2017 оны 2 сарын 24 өдрийн “№15 тоот албан шаардлагаар “Атар өргөө” ХХК-ийн үнэт цаасны арилжааг түр хугацаагаар зогсоолоо.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN